



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2018

8-Р САР

Э-сонин

61-р дугаар






Үнэт цаасны зах зээл

Зах зээлийн тойм


/2018.08.31-ний өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	23
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	3,276,907,255.73
Хувьцаа /анхдагч/	0
Хувьцаа /хоёрдогч/	2,051,215,395.73
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	1,225,691,860.00
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	18,187,107
Хувьцаа /анхдагч/	0
Хувьцаа /хоёрдогч/	10,156,541
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	11,614
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	3,577


Зах зээлийн үнэлгээ




TOP-20 индекс



MSE A индекс



MSE B индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	222
100% төрийн өмчит	19
Төрийн өмчийн оролцоотой	12
Хувийн өмчийн	119
I ангилал	13
II ангилал	42
III ангилал	167

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	59
Үүнээс:	
Брокер, Дилер	50
Андеррайтер	23
Хөрөнгө оруулалтын зөвлөх	13



Үнэт цаасны зах зээл

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны гишүүн компаниуд

/2018.08.31-ний байдлаар/

Симб ол	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн /авсан, зарсан/ (₮)
		Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	
1	Голомт Капитал ХХК	1,188,370.00	343,547,534.20	1,591,536.00	208,933,344.90	552,480,879.11
2	Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК	3,181,180.00	265,788,324.10	3,365,607.00	257,066,519.90	522,854,843.98
3	Бумбат-Алтай ХХК	1,210,468.00	205,938,883.60	1,506,043.00	267,499,469.10	473,438,352.67
4	Ти Ди Би Капитал ХХК	1,156,554.00	248,604,556.30	590,513.00	158,018,340.30	406,622,896.60
5	Гаули ХХК	1,250,356.00	232,159,519.20	376,329.00	91,773,395.80	323,932,914.97
6	БиДиСек ХК	510,297.00	178,067,217.10	299,851.00	112,910,069.20	290,977,286.27
7	Стандарт инвестмент ХХК	200,252.00	78,477,809.40	752,514.00	161,391,306.60	239,869,116.04
8	Монсек ХХК	217,069.00	126,133,923.60	132,800.00	86,507,385.00	212,641,308.58
9	Новел инвестмент ХХК	455,311.00	134,235,669.50	175,120.00	58,927,791.29	193,163,460.74
10	Ард секюритиз ХХК	471,040.00	100,522,520.40	240,691.00	72,711,343.90	173,233,864.29
11	Монгол секюритиес ХК	836.00	5,778,150.00	349,265.00	153,915,226.90	159,693,376.92
12	Ард капитал групп ХХК	127,467.00	37,182,441.29	58,874.00	81,911,771.50	119,094,212.79
13	Тэсо Инвестмент ХХК	58,713.00	23,162,559.00	161,548.00	79,121,697.62	102,284,256.62
14	Санар ХХК	6,217.00	1,021,764.15	120,121.00	78,618,100.20	79,639,864.35
15	Дэлгэрхангай секюритиз ХХК	70.00	1,540,000.00	4,935.00	26,602,034.81	28,142,034.81
16	Блүмсбюри секюритиес ХХК	6,379.00	10,428,540.00	51,927.00	16,425,634.80	26,854,174.80
17	Гендекс ХХК	15.00	124,650.00	33,698.00	19,943,621.00	20,068,271.00
18	Зэргэд ХХК	15,159.00	6,616,528.90	21,982.00	11,487,459.00	18,103,987.90
19	Дархан брокер ХХК	13,673.00	7,593,642.07	25,727.00	9,681,109.20	17,274,751.27
20	Хүннү Эмпайр ХХК	3,205.00	11,996,250.00	17,784.00	4,161,140.00	16,157,390.00

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2018.08.31-ний байдлаар/

№	Сим- бол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /₮/	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /Нэгж/	Өөрчлөлт /%/
1	LEND	ЛЭНДМН ББСБ	7,841,536	534,927,102	75	64	68.67	-4.53
2	APU	АПУ	629,973	369,752,110	623	570	571.32	-30.35
3	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ	530,180	187,083,121	378	325	344.04	-28.32
4	MCH	МОН.ЦАХИЛГААН ХОЛБОО	321,411	152,171,830	540	471	540.00	30.00
5	ITLS	АЙТҮҮЛС	165,617	20,563,479	130	115	115.53	-14.47
6	SUU	СҮҮ	119,764	25,345,866	229	200	214.45	-2.22
7	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС	106,189	65,928,947	680	550	636.90	37.90
8	HGN	ХӨХ ГАН	103,869	9,146,213	109	76	108.00	12.00
9	MRX	МЕРЕКС	48,177	1,427,147	33	29	29.00	-1.00
10	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	45,413	26,790,455	620	540	590.00	6.20
11	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	41,863	6,275,461	154	146	146.00	-4.00
12	RMC	РЕМИКОН	38,596	1,509,510	40	35	35.01	-3.99
13	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	33,093	2,294,729	80	64	64.00	-12.39
14	JLT	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ	23,933	4,315,950	188	168	168.00	-20.90
15	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	23,448	11,661,857	520	425	500.00	20.00
16	TTL	ТАВАН ТОЛГОЙ	17,498	140,375,185	8,800	6,500	6,865.00	-1,575.00
17	JIV	ЖИНСТ УВС	17,429	27,066,112	1,640	1,422	1,470.00	-74.00
18	HZB	ГАН ХЭРЛЭН	15,000	57,570,000	3,838	3,838	3,838.00	500.00
19	GOV	ГОВЬ	11,078	322,646,160	35,760	24,000	30,840.00	5,840.00
20	BDS	БИДИСЕК	3,387	3,370,053	1,000	970	1,000.00	0.00



Үнэт цаасны зах зээл

Ханшийн өсөлттэй хувьцаа

/2018.08.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /₮/	Өөрчлөлт /%/
			2018-08-01	2018-08-31		
1	ХӨСӨГ ТРЕЙД	700	1,430.00	1,890.00	460.00	32.17
2	ГОВЬ	11,078	25,000.00	30,840.00	5,840.00	23.36
3	НАКО ТҮЛШ	53	150.00	172.50	22.50	15.00
4	ЦУУТАЙЖ	589	188.00	216.20	28.20	15.00
5	ГАН ХЭРЛЭН	15,000	3,338.00	3,838.00	500.00	14.98
6	ХӨХ ГАН	103,869	96.00	108.00	12.00	12.50
7	УСЖУУЛАХ	298	600.00	665.00	65.00	10.83
8	ГУРИЛ ТЭЖЭЭЛ БУЛГАН	1	1,466.00	1,600.00	134.00	9.14
9	УБ БҮК	3,037	371.00	400.00	29.00	7.82
10	ШАРЫН ГОЛ	1,318	2,100.00	2,250.00	150.00	7.14
11	ЭРДЭНЭ РЕСУРС	106,189	599.00	636.90	37.90	6.33
12	МОН.ЦАХИЛГААН ХОЛБОО	321,411	510.00	540.00	30.00	5.88
13	МАТЕРИАЛИМПЕКС	102	9,000.00	9,500.00	500.00	5.56
14	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	23,448	480.00	500.00	20.00	4.17
15	ХАЙ БИ ОЙЛ	1,330	55.00	57.00	2.00	3.64
16	ДАРХАН НЭХИЙ	634	19,000.00	19,270.00	270.00	1.42
17	МОНГОЛ ШУУДАН ХК	45,413	583.80	590.00	6.20	1.06
18	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	103	90,000.00	90,080.00	80.00	0.09
19	МАХИМПЕКС	2,164	2,601.00	2,602.00	1.00	0.04

Ханшийн бууралттай хувьцаа

/2018.08.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (₮)		Ханшийн өөрчлөлт (₮)	Өөрчлөлт %
			2018-08-01	2018-08-31		
1	НОЁТ ХАЙРХАН	430	1,000.00	600.00	-400.00	-40.00
2	ТАВАН ТОЛГОЙ	17,498	8,440.00	6,865.00	-1,575.00	-18.66
3	ТЕХНИКИМПОРТ	10	22,000.00	18,000.00	-4,000.00	-18.18
4	МОНГОЛ ШИЛТГЭЭН	277	478.90	400.00	-78.90	-16.48
5	ЖЕНКО ТУР БЮРО	33,093	76.39	64.00	-12.39	-16.22
6	ХАР ТАРВАГАТАЙ	1	10,500.00	8,925.00	-1,575.00	-15.00
7	МОННООС	1	2,900.00	2,500.00	-400.00	-13.79
8	АЙТҮҮЛС	165,617	130.00	115.53	-14.47	-11.13
9	СТАНДАРТ НООС	7	450.00	400.00	-50.00	-11.11
10	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ	23,933	188.90	168.00	-20.90	-11.06
11	ЭРДЭНЭТ АВТОЗАМ	12	840.00	750.00	-90.00	-10.71
12	РЕМИКОН	38,596	39.00	35.01	-3.99	-10.23
13	БӨХӨГ	25	3,000.00	2,700.00	-300.00	-10.00
14	ТАХЬ КО	120	15,500.00	14,000.00	-1,500.00	-9.68
15	АДУУНЧУЛУУН	542	2,300.00	2,100.00	-200.00	-8.70



“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ЗАХИАЛГЫН НЭЭЛТ, ЦАН ЦОХИХ ЁСЛОЛ БОЛЛОО

Монголын хөрөнгийн биржийн 3-р ангилалд бүртгэлтэй, хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулдаг “Хөвсгөл Алтан Дуулга” ХК-ийн нэмэлт үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2018.08.08-ны авч эхлэхтэй холбогдуулан УИХ-ын гишүүн М.Оюунчимэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга С.Даваасүрэн, Монголын хөрөнгийн биржийн дэд захирал О.Хуягцогт, “Хөвсгөл Алтан Дуулга” ХК-ийн гүйцэтгэх захирал Д.Дуламсүрэн болон “Бумбат-Алтай ҮЦК” ХХК-ийн ТУЗ-ийн дарга Ш.Батжаргал нар Монголын хөрөнгийн биржийн 5,780 дахь удаагийн арилжааг эхлүүлэх хүндэтгэлийн цанг цохих ёслолын үйл ажиллагаанд оролцлоо.

75 жилийн түүхтэй тус компани нь 1994 онд төрийн өмч, хувьчлалын хүрээнд Монголын хөрөнгийн биржид бүртгэгдсэн бөгөөд үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр Монголын хөрөнгийн зах зээлд үнэт цаасаа гаргаж, хөрөнгө татан төвлөрүүлж буй хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарын анхны компани болж байна.

“Хөвсгөл Алтандуулга” ХК нь нийт 4.4 сая ширхэг буюу 28%-тай тэнцэх хувьцаа нэмж гаргах замаар 3.74 тэрбум төгрөг татан төвлөрүүлж, эргэлтийн хөрөнгийн санхүүжилтэнд зарцуулахаар төлөвлөж байгаа бөгөөд үнэт цаасны худалдан авах захиалгыг Монголын хөрөнгийн биржийн гишүүн үнэт цаасны компаниудаар дамжуулан 2018 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 13 цаг хүртэл хүлээн авлаа.

“МАНДАЛ ДААТГАЛ” ХХК НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛЛОО

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн А/74 тоот тушаалаар “Мандал даатгал” ХХК-ийн нэг бүр нь 1000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 6,243,016 ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлийн I ангилалд бүртгэснийг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн хурлаар хэлэлцэж, тус компанийн нийт гаргасан хувьцааны 25 хувь буюу 1,560,754 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 4800 төгрөгийн тогтоосон үнээр олон нийтэд санал болгон худалдахыг зөвшөөрсөн байна.

“АРД ДААТГАЛ” ХХК НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛЛОО

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн А/74 тоот тушаалаар “Ард даатгал” ХХК-ийн нэг бүр нь 200 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, нийт 25 сая ширхэг

энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлийн I ангилалд бүртгэснийг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн хурлаар хэлэлцэж, тус компанийн нийт гаргасан хувьцааны 30 хувь буюу 7.5 сая ширхэг хувьцааг нэг бүрийг нь 700 төгрөгийн тогтоосон үнээр олон нийтэд санал болгон худалдахыг зөвшөөрсөн байна.

“БИ ДИ СЕК ҮЦК” ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АНГИЛЛЫГ АХИУЛЛАА

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 20 дугаар зүйлийн 20.2, 20.3.6 дахь заалтууд болон ангилал ахиулах тухай “Би Ди Сек” ХК-ийн 18/314 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт зэргийг тус тус үндэслэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн А/92 тоот тушаалаар “Би Ди Сек ҮЦК” ХК-ийн үнэт цаасыг “II” ангиллаас ахиулан “I” ангилалд бүртгэлээ.

БҮРТГЭЛЭЭС ХАСАГДАХ НӨХЦӨЛ ҮҮССЭН НЭР БҮХИЙ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН АНХААРАЛД

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 23.11 дэхь заалтанд үнэт цаасны хөрвөх чадвар муудсан, Биржээс тогтоосон шалгуур, шаардлагыг биелүүлж чадахгүй болсон нь тогтоогдсон, бүртгэлтэй байх хугацаанд тогтмол биелүүлэх үүрэг болон хууль, дүрэм, журам, гэрээгээр, хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй, жилийн үйлчилгээний хөлсийг 2 жилээс дээш хугацаанд төлөөгүй, үнэт цаасны арилжааг зогсоосноос хойш 1 жилээс дээш хугацаанд арилжаа сэргээгүй буюу арилжааг зогсоох нөхцөл шалтгаан нь арилаагүй зэрэг болон хууль журамд заасан бусад үндэслэлээр үнэт цаасыг Биржийн бүртгэлээс хасна гэж тусгасан байдаг.

Үүний дагуу, хувьцааны хөрвөх чадвар хангалтгүй, хувьцааны арилжааны идэвх сул нэр бүхий 130 компани, үүргийн хэрэгжилт хангалтгүй 95 компани, арилжаа нь зогссон 32 компани Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлээс хасагдах нөхцөл үүссэн тул холбогдох журам, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, журмын шалгуур, шаардлагыг хангаж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн зүгээс тус компаниудад анхааруулж байна.



“СҮҮ” ХК 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй "Сүү" ХК нь 2018 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн бирж дээр 2018 оны 8 дугаар сарын 9-ний өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа.

2018 оны эхний хагас жилд "Сүү" ХК-ийн цэвэр борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 45 хувиар өсч, 35 тэрбум төгрөгт, цэвэр ашгийн хэмжээ 8.3 хувиар өсч, 2.2 тэрбум төгрөгт тус тус хүрсэн үзүүлэлттэй байна.

Компани нь тайлант хугацаанд шинэ техник, технологи нэвтрүүлснээс гадна 2017 онд олон нийтэд санал болгон худалдсан, хөрөнгийн зах зээлийн хамгийн өндөр үнийн дүнтэй компанийн өрийн хэрэгсэл болох "Сүү бонд"-ийн эргэн төлөлтийг хийсэн байна. Түүнчлэн, сүү бэлтгэн нийлүүлэгчдээ чадавхижуулах, тэднийг дэмжих чиглэлээр шат дараалсан ажлууд авч хэрэгжүүлсэн бөгөөд тайлант хугацаанд сүүний татан авалт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 51.4 хувиар нэмэгдсэн нь түүхий эдийн нийлүүлэлт нь хүртээмж багатай, улирлын хамааралтай үйлдвэрлэлийн хувьд чухал үзүүлэлт болсон байна.

“ГОВЬ” ХК 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй "Говь" ХК нь 2018 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн бирж дээр 2018 оны 8 дугаар сарын 9-ний өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа.

2018 оны эхний хагас жилд "Говь" ХК-ийн борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 64 хувиар өсч, 55.6 тэрбум төгрөгт, цэвэр ашгийн хэмжээ 30 хувиар өсч, 4.4 тэрбум төгрөгт тус тус хүрсэн үзүүлэлттэй байна.

Компани нь тайлант хугацаанд гадаад зах зээл дэхь борлуулалтаа нэмэгдүүлэх талаар идэвхтэй ажилласны дүнд Хятад, Герман, Турк зэрэг улсуудад франчайз дэлгүүр нээснээс гадна www.amazon.com цахим хуудсаар дамжуулан бүтээгдэхүүнээ борлуулж эхлээд байна.

Цаашид энэ онд багтаан үйлдвэрийн өргөтгөл хийх, Төв аймгийн Сэргэлэн суманд анхан шатны цогц үйлдвэрийг ашиглалтад оруулах, Сүхбаатарын талбайн хажууд 1745 м.кв талбай бүхий UB galleria дэлгүүр болон гадаад зах зээлд дахин 5 франчайз дэлгүүрийг нээж ажиллуулахаар төлөвлөсөн байна.

“МИК ХОЛДИНГ” ХК 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй "МИК Холдинг" ХК нь 2018 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн бирж дээр 2018 оны 8 дугаар сарын 10-ны өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа.

2018 оны эхний хагас жилд "МИК Холдинг" ХК-ийн цэвэр борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.7 хувиар өсч, 115.7 тэрбум төгрөгт, цэвэр ашгийн хэмжээ 17 хувиар буурч, 30.8 тэрбум төгрөгт тус тус хүрсэн үзүүлэлттэй байна.

Компани нь цаашид ипотекийн зээлээр баталгаажсан бондын багцыг худалдах авах ажиллагааг үргэлжлүүлэн "МИК Актив ТЗК 16-24" ХХК хүртэл үүсгэн байгуулах, шинэ төрлийн барьцаат үнэт цаас гаргах, эрсдлийн удирдлагын тогтолцоонд олон улсын стандартыг нэвтрүүлэх, олон улсын банк санхүүгийн байгууллагуудыг хувыцаа эзэмшигчдийн бүтцэд оруулах зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөжээ.

“ТАВАН ТОЛГОЙ” ХК 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй "Таван толгой" ХК нь 2018 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн бирж дээр 2018 оны 8 дугаар сарын 13-ны өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа.

2018 оны эхний хагас жилд "Таван толгой" ХК-ийн цэвэр борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 64 хувь буурч, 90.5 тэрбум төгрөгт, цэвэр ашгийн хэмжээ 66 буурч, 19.3 тэрбум төгрөгт тус тус хүрсэн үзүүлэлттэй байна.

Компани нь 2018 онд 4 сая тн нүүрс олборлон борлуулах төлөвлөгөөтэй байсан боловч 2018 оны 5 сараас хойш Сангийн яам болон мэргэжлийн хяналтын байгууллагаас шалгалт хийж, борлуулалтын үйл ажиллагааг 2 сарын хугацаатай зогсоосон байна. Нүүрсний ханш өндөр өсөлттэй байгаа одоо үед борлуулалтын үйл ажиллагааг зогсоосон нь компанид төдийгүй улсад нэн хохиролтой байгаа тул үүссэн асуудлыг яаралтай шийдвэрлэж, үйл ажиллагааны хязгаарлалтыг зогсоох талаар идэвхтэй ажиллаж байгаа талаар компанийн удирдлагын зүгээс тайлбарлалаа.



“АЙ ТҮҮЛС” ХК 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 2-р ангилалд бүртгэлтэй, мэдээлэл технологийн "Ай түүлс" ХК нь 2018 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн бирж дээр 2018 оны 8 дугаар сарын 13-ны өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа.

2018 оны эхний хагас жилд "Ай түүлс" ХК-ийн нийт борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 39.4 хувиар өсч, 439.3 сая төгрөгт, цэвэр ашгийн хэмжээ 3 дахин өсч, 62.4 сая төгрөгт тус тус хүрсэн үзүүлэлттэй байна.

Компани нь тайлант хугацаанд төрийн мэдээллийн ХУР системийг хувийн хэвшлийн байгууллагуудад хүргэхэд хамтран ажилласны зэрэгцээ Япон улсад блокчэйн технологид суурилсан үйлчилгээ, крипто валют олборлох үйлчилгээг үзүүлэхээр болсон байна. Цаашид, үнэт цаасны танилцуулганд тусгасны дагуу хувьцаа эзэмшигчдээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөр модуляр дата төвийг ашиглалтанд оруулж, блокчэйн дата төвийн цогц үйлчилгээ эрхлэх, олон улсын чанарын ISO 9001, ISO 27001 стандартад нийцсэн үйлчилгээг төрийн болон хувийн хэвшлийн ААН-үүдэд хүргэх зэрэг зорилтууд тавин ажиллаж байгааг компанийн зүгээс мэдээллээ.

“ДАРХАН НЭХИЙ” ХК 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй "Дархан Нэхий" ХК нь 2018 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн бирж дээр 2018 оны 8 дугаар сарын 16-ны өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа.

2018 оны эхний хагас жилд "Дархан Нэхий" ХК-ийн цэвэр борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.5 хувиар буурч, 5.3 тэрбум төгрөгт хүрсэн ч компанийн зүгээс оны эцэс гэхэд борлуулалтыг өмнөх оноос 44 хувиар өсгөх зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд энэхүү зорилтын хүрээнд үйлдвэрлэлийн хүчин чадлаа өргөжүүлж, үстэй боловсруулах шугамыг суурилуулах, нэхий боловсруулах явцад хаягдал болдог ноосыг угаах автомат үйлдвэрийг ашиглалтанд оруулснаас гадна энэ ондоо багтаан 100,000 ширхэг эко арьсыг Европ уруу экспортлохоор ажиллаж байна.

Компани үйлдвэрлэлийн хаягдлыг бууруулж, эко үйлдвэрлэл эрхлэх чармайлт гарган усны болон химийн материалын дахин ашиглалтыг арьс шир боловсруулах үйлдвэрүүддээ нэвтрүүлсэн байна. Цаашид усны дахин ашиглалтыг 80-90%-д хүргэх, шохойны дахин ашиглалтыг оруулах, гарч байгаа халимаа дахин ашиглаж арьсны боловсруулалтын дэвтээлэг, угаалгын шатанд ашиглах саванг туршилтын журмаар гаргасан байна.

"ГОВЬ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Говь" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2018 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 26 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 10:00 цагт хуралдуулахаар болсон тул хувьцаа эзэмшигчид та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хурлын тов: 2018 оны 10-р сарын 3-ны 10:00 цагт

Хуралдах газар: "Говь" ХК-ний Төв дэлгүүрийн дэргэдэх "Мираж" гэр ресторан

Бүртгэх өдөр: 2018 оны 9-р сарын 13

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн хувьцааг хуваах тухай асуудлыг хэлэлцэж батлах;

Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж, батлах.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцахыг хүсвэл 2018 оны 9-р сарын 3-ны өдрөөс эхлэн өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандах эсхүл ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд "Говь"ХК-ийн төв байранд байрлах Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын өрөөнд ирж танилцаж болно.

Саналын хуудсаар урьдчилан санал өгөх хувьцаа эзэмшигчид харилцдаг үнэт цаасны компани дээрээ очиж хурлын материалтай танилцан, саналын хуудсаа бөглөж, үнэт цаасны компаниар дамжуулан эсхүл доорх хаягаар 2018 оны 9-р сарын 28-ний өдрөөс өмнө ирүүлнэ үү.

Шуудангийн хаяг:

Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36/434,
"Говь"ХК

Холбоо барих:

Хурал зохион байгуулах комиссын
дарга: Утас: 70139977 /1002/

ТУЗ-ийн нарийн бичгийн
дарга: Утас: 343713 /1193/,
94118277 Email: selenge.m@gobi.mn



“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Хөсөг трейд” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2018 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 4 тоот шийдвэрийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 10 дугаар сарын 04-ний өдөр зарлан хуралдуулахаар боллоо.

Хувьцаа эзэмшигчдийн хуралдах хугацаа: 2018.10.04-ний өдрийн 10:00 цагт

Бүртгэх өдөр: 2018.09.13

Хуралдах газар: Улаанбаатар хот, БГД 20-р хороо "Хөсөг трейд" ХК-ийн өөрийн байр

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Нэр бүхий хувьцаа эзэмшигчээс гаргасан хүсэлтийн дагуу хувьцааны өмчлөлийн бүртгэлд өөрчлөлт оруулах эсэх

2. Бусад асуудал

Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:

Ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд УБ хот, БГД 20-р хороо "Хөсөг трейд" ХК-ийн байранд

Хуралд биеэр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг 2018 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 09:00 цаг хүртэл компанийн байранд болон брокерын компаниудаар дамжуулан хүлээн авна.

Хурал зохион байгуулах комисс: 99999064, Имэйл: nyamka0630@yahoo.com

“МОНИНЖБАР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Монинжбар” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2018 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 20 тоот тогтоолын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдөр зарлан хуралдуулахаар боллоо.

Хувьцаа эзэмшигчдийн хуралдах хугацаа: 2018.10.05-ны өдрийн 15:00 цагт

Бүртгэх өдөр: 2018.09.03

Хуралдах газар: Чингэлтэй Дүүрэг 6-р хороо, Бага тойруу 24/3 "Монинжбар" ХК-ийн өөрийн байр

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан;

2. Компанийн хэтийн зорилт, 2019 оны төлөвлөгөө;

3. ТУЗ – ийн ердийн болон хараат бус гишүүнд түр томилогдсон гишүүдийг баталгаажуулах;

4. Компанийн нэрийг өөрчлөх тухай.

Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:

Ажлын өдрүүдэд Чингэлтэй Дүүрэг 6-р хороо, Бага тойруу 24/3 "Монинжбар" ХК-ийн байранд болон харилцдаг брокерын компани, www.facebook.com/moninjbarg хаягаар дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

Хуралд биеэр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг 2018 оны 9 дугаар сарын 23-ны өдрийг хүртэл компанийн байранд хүлээн авна.

Хурал зохион байгуулах комисс: 311585, 90045328

“МОНГОЛ ШЕВРО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Монгол Шевро” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2018 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 20 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр зарлан хуралдуулахаар боллоо.

Хувьцаа эзэмшигчдийн хуралдах хугацаа: 2018.09.29-ний өдрийн 10:00 цагт

Бүртгэх өдөр: 2018.09.10-ны өдөр

Хуралдах газар: ХУД-ийн 2-р хороо, "Монгол шевро" ХК-ийн өөрийн байр

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компаний 2017 оны тайланд өгсөн ТУЗ-ийн үнэлэлт, дүгнэлт;

2. Компаний дүрэмд оруулах өөрчлөлтүүд;

3. Зарим их хэмжээний хэлцлийг батлах;

4. ТУЗ-ийн нэр дэвшигчдийг хэлэлцэн батлах.

Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:

Ажлын өдрүүдэд ХУД-ийн 2-р хороо, "Монгол шевро" ХК-ийн байранд болон харилцдаг брокерын компаниас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу. .

Хурал зохион байгуулах комисс: Ц.Түмэн-Өлзий 99116018, 99116621

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Чингис Хааны талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN